БАТЛАВ:
ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ,
ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА

А.ЭНХМАНЛАЙ

"ХАЯГИЙН НЭГДСЭН СИСТЕМИЙН ХӨГЖҮҮЛЭЛТ (ХАЯГ ОЛГОХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ АВТОМАТЖУУЛАХ, ЦАХИМЖУУЛАХ АЖИЛ)"-ЫН АЖЛЫН ДААЛГАВАР

2024 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр

Дугаар: А08/2024-04

Улаанбаатар хот

Д/Д	Ажлын нэр, төрөл	Тайлбар
1.	Ажлын үндэслэл	- Газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.8 дахь заалт; - Хаягжуулалтын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.6 дахь заалт; - Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.7.2 дахь заалт; - "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 5.3.8 дахь заалт; - Засгийн газрын 2019 оны "Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах журам батлах тухай" 325 дугаар тогтоол; - Засгийн газрын 2022 оны "Хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн системийг хэрэглээнд нэвтрүүлэх тухай" 180 дугаар тогтоол; - Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө;
2.	Ажлын зорилго, шийдвэрлэх асуудал	Хаягийн мэдээллийн системд холбогдох нэмэлт хөгжүүлэлтийг хийж, үйл ажиллагааг боловсронгуй болгох, хаяг олгох үйл ажиллагааг бүрэн автоматжуулах, цахимжуулах, нийслэлийн 9 дүүргийн хэмжээнд хаяг олгоход оршино.
3.	Хамрах хүрээ	Монгол Улсын хэмжээнд, Хаягийн мэдээллийн системийн хөгжүүлэлт, нийслэлийн 9 дүүргийн хэмжээнд хаяг олгох
4.	Гүйцэтгэх хугацаа	Гэрээ байгуулсан өдрөөс хойш 6 сарын хугацаанд.
5.	Ажлын иж бүрдэл	1. Нийслэлийн 9 дүүргийн хэмжээнд хаяг олгох: - Нийслэлийн хаягтай холбоотой өгөгдлүүдийг хөрвүүлж оруулах; - Хаягийн мэдээллийн системд оруулсан мэдээллийг шалгах; - Шаардлагатай засвар хийх - Хаяг олгох; 2. Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системтэй холбогдож мэдээлэл авах боломжийг бүрдүүлэх: - Хилийн цэсийг холбох, тухай бүр шинэчлэх; - Нэгж талбарын ангилал /ГНС-н ангилал/ авах, шинэчлэх; - Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системээс газрын нэгж талбар, барилга, төлөвлөлтийн нэгж талбарыг авах тогтмол шинэчлэх; - Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд туссан зам,

д/д	Ажлын нэр, төрөл	Тайлбар
		гудамж, нэгж талбарын орц, гарцыг тогтмол шинэчлэх; - Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу шинээр бий болох суурьшлын бүсийн заагийг шинэчлэх; 3. Хаягийн мэдээллийн системд тохиргооны төрлийг бүртгэж ангилах боломжийг бүрдүүлэх: - Давхаргын ангиллын тохиргоог шинэчлэх; - Зам, гудамж, орц, гарцны хаягийн төлөвийг бүртгэж ангилах тохиргоог шинэчлэх; 4. Мэдээллийн санд давхаргын бүртгэлийг тус бүрээр бүртгэх боломжийг бүрдүүлэх: - Нэгж талбар, барилга, зам, гудамжны эхлэл, төгсгөлийн цэгийг давхарга бүрээр бүртгэх; - Шуудангийн бүсчлэл, суурьшлын бүс, суурьшлын бүсийн төв цэгээр давхарга үүсгэх; - Газар зүйн нэр бүхий давхарга бий болгох; 5. Гудамжны нэрийг бөөнөөр болон хэсэгчлэн бүртгэх боломжийг бүрдүүлэх: - Холбогдох замыг бүртгэж, замын эхлэл төгсгөлийн цэгээс хамаарч гудамжны эхлэл, төгсгөлөө тооцох; - Гудамжны нэр олгосон ИТХ-ын тогтоол, шийдвэрийг хялбараар бүртгэх; - Гудамж нь холбогдсон замын нэрээр бүртгэгдэх боломжийг бүрдүүлэх; 6. Газрын нэгж талбарын хаягийг бөөнөөр болон хэсэгчлэн олгох, баталгаажуулах, хаяг олгох ажлыг бүрэн автоматжуулах боломжийг бүрдүүлэх: - Нэгж талбарын орц, гарц оруулах, гудамжтай холбох ажлыг автоматжуулах; - Нэгж талбарыг гудамжтай холбох, гудамжны тал болон зай бодох ажиллагааг бүрэн автоматжуулах; - Хаягийн мэдээллийн систем дэх түүхчлэлийн бүртгэл мэдээллийн харах боломжийг бүрдүүлэх; - Хаяг олгогдсон үйл явцын төлөв шинэчлэх: - Захиалагчийн саналын дагуу нэмэлт хөгжүүлэлт хийх: 7. Барилгат түр хаяг олгох, баталгаажуулах: - 21 аймгийн хэмжээнд ашиглагдаж буй хот, байгуулалтын /urban.gov.mn/ системд бүртгэгдсэн барилга байгууламжийн мэдээллийг холбох, турших; - Нийслэлийн хэмжээнд ашиглагдаж буй хот, байгуулалтын /ebarilga.mn/ системд бүртгэгдсэн барилга байгууламжийн мэдээллийг холбох, турших; 8. Улсын хэмжээний хаягийн мэдээ, мэдээллийг иргэд олон нийтэд egazar.gov.mn системээр дамжуулан хүргэх боломжийг бүрдүүлэх: - Хаягийн нээлттэй вэб сайтийн нүүр хуудас, хаягийн хайлт, дэлгэрэнгүй мэдээллийг хайх, хэрэглэхэд хялбар байх боломжийг бүрдүүлэх; 9. Нээлттэй веб сервис хэрэглээнд нэвтрүүлэх боломжийг бүрдүүлэх: - Хаягийн иж бүрдэл /газрын нэгж талбар, барилга/, - Гудамжны мэдээлэл /гудамжны нэр, тоотын дугаар/, - Замын мэдээлэл /эхлэл, төгсгөх цэгээс хамаарч замын мэдээлэл өгөх/ 10. Хаягийн мэдээллийн сангийн хэрэглэгчид тайлан гаргах

д/д	Ажлын нэр, төрөл	Тайлбар
		боломжийг бүрдүүлэх: - Хаягийн мэдээллийн системээс шинээр гудамж, зам, талбайн нэр олгосон, нэгж талбар, орц, гарцын тайлан гаргах; - Захиалагчийн саналын дагуу нэмэлт хөгжүүлэлт хийх: 11. Системийн баримт бичиг болон тайлан, гарын авлага боловсруулж захиалагч талд хүлээлгэн өгч, баталгаат хугацаанд засвар үйлчилгээг хийж хэвийн үйл ажиллагааг хангах: - Системийн баримт бичиг болон гарын авлага боловсруулах; - Хөгжүүлэлтийн ажил хийж гүйцэтгэснээс хойш 1 жилийн хугацаанд шаардлагатай нэмэлт засварыг цаг тухай бүрт нь хийж, хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллах; - Захиалагчийн саналын дагуу нэмэлт хөгжүүлэлт хийх: 12. Холбогдох сургалт зохион байгуулж, мэргэжил арга зүйгээр хангах: - Системийн admin хэрэглэгчийн сургалт; - Системийн хэрэглэгчийн сургалт;
6.	Ажлын үр дүн	- Хаягийн мэдээллийн системээс нийслэлийн хэмжээнд хаяг олгогдсон байх: - Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системтэй холбогдож мэдээлэл авах, тухай бүр шинэчлэгдэх боломж бүрдсэн байх: - Хаягийн мэдээллийн системд тохиргооны төрлийг бүртгэж ангилсан байх: - Мэдээллийн санд давхаргын бүртгэлийг тус бүрээр бүртгэсэн байх: - Гудамжны бүртгэлийг бөөнөөр болон хэсэгчлэн бүртгэх боломж бүрдсэн байх: - Нэгж талбарын хаягийг бөөнөөр болон хэсэгчлэн олгох, баталгаажуулах, хаяг олгох ажлыг бүрэн автоматжуулсан байх: - Барилгат түр хаяг олгох, баталгаажуулах ажил хийгдсэн, түр хаяг олгогддог байх: - Хаягийн мэдээллийн сангийн хэрэглэгчид шаардлагатай тайлан гаргадаг байх: - Хаягийн мэдээллийн системд нэмэлт хөгжүүлэлт хийж, иргэд олон нийтэд нээлттэй вэб систем бий болсон, хаягийн системийн үйл ажиллагааг боловсронгуй болгосон байх; - Хэрэгжүүлэх үйл ажиллагаа, чиг үүрэгт тохируулж нэмэлт хөгжүүлэлт хийгдсэн байх; - Системийн баримт бичиг, гарын авлага боловсруулж захиалагч талд хүлээлгэн өгч, баталгаат хугацаанд засвар үйлчилгээг хийж гүйцэтгэх - Холбогдох сургалт зохион байгуулж, мэргэжил арга зүйгээр хангасан байх:
7.	Боловсруулах үе шат	1. Системийн нэмэлт хөгжүүлэлттэй холбоотой, техникийн шийдлийг тодорхойлох; 2. Үндсэн үйл ажиллагааны дараалал болон процессын зураглалыг гаргах; 3. Системийн хөгжүүлэлтийг хийх, захиалагчийн саналын дагуу нэмэлт хөгжүүлэлт хийх;

д/д	Ажлын нэр, төрөл	Тайлбар
		4. Системийн туршилт, зүгшрүүлэлт хийх; 5. Захиалагч талд хүлээлгэн өгөх;
8.	Техникийн шаардлага	- Мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг өндөр түвшинд шийдсэн байх; - Төрийн нууцыг хадгалах, хамгаалах хууль болон дүрэм, журмыг баримтлан ажилласан байх; - Холбогдох мэдээллийн сантай холбогдож иргэн, хуулийн этгээдэд түргэн, шуурхай үйлчилгээ үзүүлэх боломжтой болсон байх; - Мэдээллийн чанар орон зайн мэдээллийн дэд бүтцийн өгөгдлийн стандарт шаардлагыг хангасан байх; - Систем хөгжүүлэлтийг төслийн менежментийн Agile менежментээр хийж гүйцэтгэх; - Систем хөгжүүлэлтийн үйл ажиллагаанд олон улсын жишигт нийцсэн мэдээлэл технологийн төслийн менежментийн программ хангамж ашигладаг байх, систем хөгжүүлэлтийн үйл ажиллагаа түүхчлэн хадгалагддаг байх; - Системийн хөгжүүлэлтийн кодчлол Doxegyn аргачлалаар дүрэм, стандартаар бичигддэг байх; - Системийн бичиг баримт Doxegyn аргачлалаар автоматаар гардаг байх;
9.	Ажлын хяналт, шалгалт	Захиалагчийн хяналтыг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар гүйцэтгэнэ.
10.	Баримтын төвд хүлээлгэн өгөх материал	- Ажлын явцын болон эцсийн тайланг 3 хувь; - Системийн хөгжүүлэлтийн эх кодыг тоо байдлаар 3 хувь; - Техникийн болон системийн баримт бичиг, бусад холбогдох материалыг тоон болон хэвлэмэл байдлаар 3 хувь; - Мэдээлэл технологийн төслийн менежментийн программ хангамж;
11.	Захиалагч	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар
12.	Гүйцэтгэгч	Ижил төстэй ажил хийж гүйцэтгэж байсан ажлын туршлагатай, тухайн хөгжүүлэлтийг хийж гүйцэтгэх хангалттай хүний нөөц бүхий хуулийн этгээд байх;
13.	Санхүүжилт, эх үүсвэр	102,000,000 төгрөг; /Нэг зуун хоёр сая төгрөг/ Урсгал зардал.
14.	Төрийн нууцыг хадгалах, хамгаалах	Төрийн болон албаны нууцын тухай хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад журам, зааврын дагуу төрийн нууцыг хадгалах, хамгаалах ажлыг зохион байгуулна.
	Даалгаварт тусгагдаагүй ажил	Даалгаварт тусгагдаагүй ажлыг нэмэлт нөхцөлөөр гүйцэтгэж болох ба үүнийг гэрээний тусгай нөхцөлөөр тодорхойлно.

ХЯНАСАН:

ГАЗРЫН УДИРДЛАГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА — А.АМАРСАЙХАН

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА — Г.ХАЛИУНБИГЭР

КАДАСТРЫН ХЭЛТСИЙН ДАРГА — П.БАЯНТҮМЭН

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН — Н.УРАНЧИМЭГ

БОЛОВСРУУЛСАН:

КАДАСТРЫН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН — С.ӨЛЗИЙБУЯН

.....дугаартай ажлын
даалгаврын 1 дүгээр хавсралт

"ХАЯГИЙН НЭГДСЭН СИСТЕМИЙН ХӨГЖҮҮЛЭЛТ (ХАЯГ ОЛГОХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ АВТОМАТЖУУЛАХ, ЦАХИМЖУУЛАХ АЖИЛ)"-ЫН ЗАРДЛЫН ТООЦОО

д/д	Хийж гүйцэтгэх ажил			Шаардагдах зардлын тооцоо			
				Хэмжих нэгж	Хугацаа (хоног)	Ажиллах хүч (хүний тоо)	Нийт зардал
1	Нийслэлийн 9 дүүргийн хэмжээнд хаяг олгох	Нийслэлийн хаягтай холбоотой өгөгдлүүдийг хөрвүүлж оруулах	Нэгж талбар, барилга, зам, орц, гарцыг хөрвүүлэх оруулах;	хүн/ өдөр	12	6	9,052,416
			Суурьшлын бүсийн хил, төв цэгийг				
			Шуудангийн бүсчлэл оруулах				
		Хаягийн мэдээллийн системд оруулсан мэдээллийг шалгах	Нэгж талбар, барилгын давхардлыг шалгах	хүн/ өдөр	12	6	9,052,416
			Орц, гарцыг нэгж талбартай орон зайн хувьд холбогдсон эсэхийг шалгах				
			Холбогдоогүй болон холбогдох боломжгүй орц, гарцуудыг өөр төлөвтэй болгох				
			Бүх нэгж талбар гудамжтай холбогдсон байгаа эсэхийг шалгах				
			Гудамжтай холбогдоогүй нэгж талбаруудыг холбох боломжгүй бол өөр төлөвтэй болгох				
			Бүх орц, гарц гудамжтай холбогдсон байгаа эсэхийг шалгах				
		Шаардлагатай засвар хийх	Нэгж талбарын тал болон гудажны зайг тооцоолж хадгалах	хүн/ өдөр	6	4	3,017,472
			Гудамжтай холбогдоогүй орц, гарцуудыг холбох боломжгүй бол өөр төлөвтэй болгох				
			Боломжит орц, гарцны тал болон гудажны зайг тооцоолж хадгалах				
		Хаяг олгох	Нэгж талбар хаяг олгох	хүн/ өдөр	20	4	10,058,240
			Орц, гарцанд хаяг олгох				
			Нэгж талбарт хамаарах барилгад хаяг олгох				
			Нэгж талбар болон барилгад олгогдсон хаягуудыг хаягын системд оруулах				
2	Хаягийн мэдээллийн системийн хөгжүүлэлт	Газрын удирдлагын системтэй холбогдож мэдээлэл авах боломжийг бүрдүүлэх	Хилийн цэсийг холбох, тухай бүр шинэчлэх	хүн/ өдөр	10	4	5,029,120
			Нэгж талбарын ангилал/ГНС-н ангилал/ авах, шинэчлэх				
			Барилгын ангилал авах, шинэчлэх				
			Нэгж талбар авах, шинэчлэх				

	Хаягийн мэдээллийн системийн хөгжүүлэлт		Барилга авах, шинэчлэх				
			ГЗБТ-н нэгж талбар авах, шинэчлэх				
			ГЗБТ-н нэгж талбарын орц гарц авах, шинэчлэх				
			ГЗБТ-н зам авах, шинэчлэх				
			ГЗБТ-н гудамж авах, шинэчлэх				
			ГЗБТ-н суурьшлын бүсийн зааг авах, шинэчлэх				
3		Хаягийн мэдээллийн системд тохиргооны төрлийг бүртгэж ангилах боломжийг бүрдүүлэх	Давхаргын ангилалын тохиргоо	хүн/ өдөр	10	4	5,029,120
			Замын төрөл				
			Гудамжны төрөл				
			Орц, гарцны төрөл				
			Хаягийн төлөв				
4		Мэдээллийн санд давхаргын бүртгэлийг тус бүрээр бүртгэх боломжийг бүрдүүлэх	Нэгж талбар	хүн/ өдөр	10	4	5,029,120
			Барилга				
			Зам				
			Гудамж болон эхлэл, төгсгөлийн цэг				
			Шууданг ийн бүсчлэл				
			Газар, усны нэрийн бүртгэл				
			Суурьшлын бүс				
			Суурьшлын бүсийн төв цэг				
5		Гудамжны бүртгэлийг бөөнөөр болон хэсэгчлэн бүртгэх боломжийг бүрдүүлэх	Холбогдох замуудыг бүртгэх	хүн/ өдөр	10	4	5,029,120
			Тогтоол, шийдвэрийг бүртгэх				
			Эхлэл, төгсгөл тодорхойлох				
			Бусад				
6		Нэгж талбарын хаягийг бөөнөөр болон хэсэгчлэн олгох, баталгаажуулах, хаяг олгох ажлыг бүрэн автоматжуулах боломжийг бүрдүүлэх,	Орц, гарц оруулах	хүн/ өдөр	18	4	9,052,416
			Гудамжтай холбох, тал болон зай бодох				
			Хаягийн түүхчлэл				
			Төлөв				
7		Барилгат түр хаяг олгох, баталгаажуулах	Хот, байгуулалтын мэдээллийн сантай холбох /urban.gov.mn/	хүн/ өдөр	10	5	6,286,400
			Хот, байгуулалт, хөгжлийн газрын мэдээллийн сантай холбох /ebarilga.mn/				
8		Нээлттэй вэб сайт хэрэглээнд нэвтрүүлэх боломжийг бүрдүүлэх	Нүүр хуудас	хүн/ өдөр	12	4	6,034,944
			Хаягийн хайлт				
			Дэлгэрэнгүй мэдээлэл				
9		Нээлттэй веб сервис хэрэглээнд нэвтрүүлэх боломжийг бүрдүүлэх	Хаягийн иж бүрдэл /Нэгж талбар, барилгын иж бүрдэл/	хүн/ өдөр	12	4	6,034,944
			Гудамжны мэдээлэл /гудамжны нэр, тоотын тоо/				
			Замын мэдээлэл /Замын эхлэх, төгсөх цэгээс хамаарч замын мэдээлэл өгөх				

10	Хаягийн мэдээллийн системийн хөгжүүлэлт	Хаягийн мэдээллийн сангийн хэрэглэгчид тайлан гаргах боломжийг бүрдүүлэх	Хаягийн мэдээллийн системээс шинээр гудамж, зам, талбайн нэр олгосон, нэгж талбар, орц, гарцын тайлан гаргах	хүн/ өдөр	12	4	6,034,944
11		Системийн баримт бичгийг боловсруулж, тайлан, гарын авлага боловсруулж захиалагч талд хүлээлгэн өгч, баталгаат хугацаанд засвар үйлчилгээг хийж гүйцэтгэх	Системийн баримт бичгийг эцсийн байдлаар боловсруулах	хүн/ өдөр	4.4	4	2,203,113
			Хөгжүүлэлтийн ажил хийж гүйцэтгэснээс хойш 1 жилийн хугацаанд шаардлагатай нэмэлт засварыг цаг тухай бүрт нь хийж, хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллах	хүн/ өдөр	12	1	1,508,736
		Холбогдох сургалт зохион байгуулж, мэргэжил арга зүйгээр хангах		хүн/ өдөр	2	2	502,912
12		Цахим системийн нэмэлт хөгжүүлэлтэд Захиалагч болон хэрэглэгчдээс гарсан саналын дагуу нэмэлт хөгжүүлэлт хийх;		хүн/ өдөр	10	3	3,771,840
Дүн							92,727,273
Албан татвар							9,272,727
Нийт дүн							***102,000,000***

** Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хорооны 2023 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 10 дугаар тогтоолын дагуу 2023 оны Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 4 дахин өсгөсөн цалингаар буюу өдрийн 125'728 төгрөгөөр тооцов.*

ХЯНАСАН:

ГАЗРЫН УДИРДЛАГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА — А.АМАРСАЙХАН

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА — Г.ХАЛИУНБИГЭР

КАДАСТРЫН ХЭЛТСИЙН ДАРГА — П.БАЯНТҮМЭН

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН — Н.УРАНЧИМЭГ

БОЛОВСРУУЛСАН:

КАДАСТРЫН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН — С.ӨЛЗИЙБУЯН